



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 26-ны өдөр

Дугаар 1/86

Эрдэнэт

Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны тушаал "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого" 2020-2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэндийн газрын дэргэдэх "Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын орон тооны бус зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. "Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын орон тооны бус зөвлөл"-ийн жилийн ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.
3. "Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын орон тооны бус зөвлөл"-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.
4. Уг тушаал гарсантай холбогдуулан 2021 оны А/30 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

### ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга	"Тэгш нуруу" Клиник эмнэлгийн захирал УАУ-ны их эмч З.Ариунжаргал
Нарийн бичгийн дарга	ЭМГ-ын УАУСЗХБИАХМ М.Бямбасүрэн
Гишүүд	"Эрдэнэт сувилал цогцолбор"-ын сэргээн засахын тасгийн эрхлэгч Д.Оюунбат "Очир увидас" эмнэлэг захирал УАУ-ны их эмч Н.Бүүвэй "Эрдэнэт медикал" төрөлжсөн эмнэлгийн УАУ-ны их эмч Б.Батням "Жаргалын ундарга" клиникийн захирал УАУ-ны их эмч М.Отгонбаяр Нийцэл ӨЭМТ-ийн УАУ-ны их эмч Ц.Оюундарь

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН, СЭРГЭЭН  
ЗАСАХЫН ОРОН ТООНЫ БУС САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Эрүүл мэндийн газрын дэргэдэх Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын орон тооны бус салбар зөвлөл /цаашид салбар зөвлөл гэх/ нь мэргэжлийн чиглэлийн бодлогыг тодорхойлох, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг боловсруулахад оролцох, тулгамдсан асуудлыг хэлэлцэх санал, дүгнэлт гаргаж орон нутгийн хэмжээнд уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, уламжлалт анагаах ухаан сэргээн засах тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, удирдан зохион байгуулах, байгууллагуудын хамтын харилцааг хангахад оршино.

1.2. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын орон тооны бус салбар зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүд бүхий 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байх ба бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар томилж чөлөөлнө.

1.3. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын орон тооны бус салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хурал байна. Гишүүдийн олонх нь ирсэн тохиолдолд мэргэжлийн зөвлөлийн хурлыг хүчинтэйд тооцно.

1.4. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын орон тооны бус салбар зөвлөлийг улиралд нэг удаа хуралдуулан, хурлаас гарсан шийдвэр, зөвлөмжийг олонхын саналаар баталж, мэргэжлийн зөвлөлийн даргын гарын үсэг зурж баталгаажуулна. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын орон тооны бус салбар зөвлөлийн дарга бусад гишүүдийн адил санал өгөх эрх эдэлнэ.

1.5. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын орон тооны бус салбар зөвлөлийн тайланг гаргаж жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэст ирүүлж архивт хүлээлгэн өгнө.

**Хоёр. Салбар зөвлөлийн чиг үүрэг**

2.1. Тухайн мэргэжлийн хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын тусламжийн эрх зүйн орчинтой холбоотой хэрэгжиж байгаа холбогдох хууль, Эрүүл мэндийн сайдын тушаал, журам, стандартыг хэрэгжүүлэн ажиллах, боловсронгуй болгоход дээд шатны байгууллагууд санал өгөх, хэрэгжилтийг ханган ажиллах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

2.2. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудад төлөвлөгөөт хяналтыг хийж, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт, туршлага солилцор уулзалт, аяныг зохион байгуулах

2.3. Уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлэх, сэргээн засахын тусламж үйлчилгээг урт болон богино хугацаагаар нотолгоонд суурилсан цогц байдлаар үзүүлэх, тусламж үйлчилгээний удирдлага, зохион байгуулалтыг зөв чиглүүлэх

2.4. Гадаад, дотоодын мэргэжлийн нийгэмлэг, холбоод, Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл хөтөлбөрийг санаачлах

## Гурав. Удирдлага зохион байгуулалт

3.1. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын орон тооны бус салбар зөвлөлийн даргын эрх, үүрэг

3.1.1. Бусад байгууллага, албан тушаалтны өмнө тухайн мэргэжлийн зөвлөлийг төлөөлөх

3.1.2. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын орон тооны бус салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг хэлэлцүүлж Эрүүл мэндийн газрын даргаар батлан хэрэгжилтийг зохион байгуулж хяналт тавих

3.1.3. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын орон тооны бус салбар зөвлөлийн хурлын товийг тогтоож хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, хурлын дэгийг батлуулах

3.2. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын орон тооны бус салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг

3.2.1. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын орон тооны бус салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын материалыг бэлтгэх, гишүүдэд урьдчилан хүргэх

3.2.2 Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын чиглэлээр үйл ажиллага явуулж буй эрүүл мэндийн байгууллагуудын төлөвлөгөөт хяналт, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт, туршлага солилцор уулзалт, аяны удирдамжыг гаргаж Эрүүл мэндийн мэндийн газрын даргаар батлуулах

3.2.3. Хурлын протоколыг хөтлөх

3.2.4. Холбогдох асуудлаар гарсан зөвлөмжийг салбаруудад хүргэх

3.3. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын орон тооны бус салбар зөвлөлийн гишүүдийн эрх, үүрэг

3.3.1 Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын орон тооны бус салбар зөвлөлийн даргын шийдвэрээр мэргэжлийн зөвлөлийг төлөөлж ажлын хэсэгт орж ажиллах

3.3.2. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын орон тооны бус салбар зөвлөлийн хурлыг таслахгүй байх, уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудад төлөвлөгөөт хяналтыг хийх

3.3.3. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засахын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, тусламж үйлчилгээнд шинэ санаа, дэвшилтэд технологийг нэвтрүүлэх талаар санал дэвшүүлж мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх